



Долоо хоног тутмын хэвлэл  
2016 оны 07 дугаар сарын 20  
№ 27 /936/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

1641

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

1646

Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол

1647

Монгол Улсын Их Хурлын  
Байнгын хорооны бүрэлдэхүүний  
тухай

Монгол Улсын Ерөнхий сайдыг  
томилох тухай

Сум, дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын ээлжит  
сонгуулийг товлон зарлах, санал  
авах өдрийг тогтоох тухай



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

532.	Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай	Дугаар 04	1641
533.	Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай	Дугаар 05	1646
534.	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай	Дугаар 06	1647
535.	Авлигатай тэмцэх газрын даргыг томилох тухай	Дугаар 07	1647

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

536.	Журам батлах тухай	Дугаар 215	1648
537.	Журамд нэмэлт оруулах тухай	Дугаар 217	1652

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар  
сарын 07-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар  
хот

#### **Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

#### ***1/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:***

- 1.Төмөрбаатарын Аюурсайхан
- 2.Октябрийн Баасанхүү



- 3.Сүхбаатарын Батболд
- 4.Лувсанвандангийн Болд
- 5.Гомбожавын Занданшатар
- 6.Данзангийн Лүндээжанцан
- 7.Батсүхийн Наранхүү
- 8.Хишгээгийн Нямбаатар
- 9.Наваан-Юндэнгийн Оюундарь
- 10.Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ
- 11.Ядамсүрэнгийн Санжмятав
- 12.Отгонбилэгийн Содбилэг
- 13.Ганзоригийн Тэмүүлэн
- 14.Агваанлуvsангийн Ундраа
- 15.Цэдэнбалын Цогзолмаа
- 16.Дамдины Цогтбаатар
- 17.Бямбасүрэнгийн Энх-Амгалан
- 18.Жадамбын Энхбаяр
- 19.Нямаагийн Энхболд

***2/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:***

- 1.Хавдисламын Баделхан
- 2.Батжаргалын Батзориг
- 3.Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
- 4.Жадамбын Бат-Эрдэнэ
- 5.Хаянгаагийн Болорчулуун
- 6.Цэдэнгийн Гарамжав
- 7.Самандын Жавхлан
- 8.Лхагвын Мөнхбаатар
- 9.Гомпилдоогийн Мөнхцэцэг
- 10.Дакейн Мурат
- 11.Ядамсүрэнгийн Санжмятав
- 12.Батсүхийн Саранчимэг
- 13.Янгугийн Содбаатар
- 14.Гомбожайн Солтан
- 15.Агваансамдангийн Сүхбат
- 16.Ганзоригийн Тэмүүлэн
- 17.Дэндэвийн Тэрбишдагва
- 18.Лхагваагийн Элдэв-Очир
- 19.Дондогдоржийн Эрдэнэбат



**3/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо:**

- 1.Октябрийн Баасанхүү
- 2.Ёндонпэрэнлэйн Баатарбилэг
- 3.Баагаагийн Баттөмөр
- 4.Магваны Билэгт
- 5.Даваагийн Ганболд
- 6.Дорждугарын Гантулга
- 7.Самандын Жавхлан
- 8.Нямтайширын Номтойбаяр
- 9.Мөнхөөгийн Оюунчимэг
- 10.Ядамсүрэнгийн Санжмятав
- 11.Даваажанцангийн Сарангэрэл
- 12.Батсүхийн Саранчимэг
- 13.Агваанлуvsангийн Ундраа
- 14.Ням-Осорын Учрал
- 15.Цэдэнбалын Цогзолмаа
- 16.Содномын Чинзориг
- 17.Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
- 18.Өлзийсайханы Энхтүвшин
- 19.Содномзундуйн Эрдэнэ

**4/Өргөдлийн байнгын хороо:**

- 1.Намсрайн Амарзаяа
- 2.Ёндонпэрэнлэйн Баатарбилэг
- 3.Магваны Билэгт
- 4.Дорждугарын Гантулга
- 5.Цэдэнгийн Гарамжав
- 6.Дорждамбын Дамба-Очир
- 7.Гомбожавын Занданшатар
- 8.Гомпилдоогийн Мөнхцэцэг
- 9.Дакейн Мурат
- 10.Мөнхөөгийн Оюунчимэг
- 11.Бөхчулууны Пүрэвдорж
- 12.Шатарбалын Раднаасэд
- 13.Даваажанцангийн Сарангэрэл
- 14.Гомбожайн Солтан
- 15.Агваансамдангийн Сүхбат



16. Дуламдоржийн Тогтохсүрэн
17. Намсрайн Цэрэнбат
18. Бямбасүрэнгийн Энх-Амгалан
19. Лувсангийн Энхболд

**5/Төрийн байгуулалтын байнгын хороо:**

1. Октябрийн Баасанхүү
2. Жалбасүрэнгийн Батзандан
3. Батжаргалын Батзориг
4. Болдын Жавхлан
5. Данзангийн Лүндээжанцан
6. Жамъянгийн Мөнхбат
7. Цэндийн Мөнх-Оргил
8. Батсүхийн Наранхүү
9. Дуламсүрэнгийн Оюунхорол
10. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ
11. Отгонбилэгийн Содбилэг
12. Долгорсүрэнгийн Сумъяабазар
13. Батбаярын Ундармаа
14. Дамдины Хаянхярваа
15. Намсрайн Цэрэнбат
16. Миеэгомбын Энхболд
17. Нямаагийн Энхболд
18. Дондогдоржийн Эрдэнэбат
19. Жаргалтулгын Эрдэнэбат

**6/Төсвийн байнгын хороо:**

1. Намсрайн Амарзаяа
2. Хавдисламын Баделхан
3. Жалбасүрэнгийн Батзандан
4. Отгоогийн Батнасан
5. Баагаагийн Баттөмөр
6. Цэрэнпилийн Даваасүрэн
7. Жамъянгийн Мөнхбат
8. Загдхүүгийн Нарантуяа
9. Батсүхийн Наранхүү
10. Нямтайширын Номтойбаяр
11. Цэндийн Нямдорж



12. Дуламсүрэнгийн Оюунхорол
13. Дуламдоржийн Тогтохсүрэн
14. Чүлтэмийн Улаан
15. Чимэдийн Хүрэлбаатар
16. Баттогтохын Чойжилсүрэн
17. Жадамбын Энхбаяр
18. Өлзийсайханы Энхтүвшин
19. Содномзундуйн Эрдэнэ

***7/Хууль зүйн байнгын хороо:***

1. Жалбасүрэнгийн Батзандан
2. Отгоогийн Батнасан
3. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
4. Лувсанвандангийн Болд
5. Жамбалын Ганбаатар
6. Даваагийн Ганболд
7. Борхүүгийн Дэлгэрсайхан
8. Лхагвын Мөнхбаатар
9. Цэндийн Мөнх-Оргил
10. Хишгээгийн Нямбаатар
11. Цэндийн Нямдорж
12. Наваан-Юндэнгийн Оюундарь
13. Бөхчулууны Пүрэвдорж
14. Шатарбалын Раднаасэд
15. Ням-Осорын Учрал
16. Дамдины Цогтбаатар
17. Баттогтохын Чойжилсүрэн
18. Лувсангийн Энхболд
19. Содномзундуйн Эрдэнэ

***8/Эдийн засгийн байнгын хороо:***

1. Төмөрбаатарын Аюурсайхан
2. Жадамбын Бат-Эрдэнэ
3. Лувсанвандангийн Болд
4. Хаянгаагийн Болорчулуун
5. Сандагийн Бямбацогт
6. Жамбалын Ганбаатар
7. Цэрэнпилийн Даваасүрэн



- 8.Дорждамбын Дамба-Очир
- 9.Борхүүгийн Дэлгэрсайхан
- 10.Болдын Жавхлан
- 11.Загдхүүгийн Нарантуяа
- 12.Долгорсүрэнгийн Сумъяабазар
- 13.Дэндэвийн Тэрбишдагва
- 14.Батбаярын Ундармаа
- 15.Чимэдийн Хүрэлбаатар
- 16.Содномын Чинзориг
- 17.Лхагваагийн Элдэв-Очир
- 18.Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
- 19.Дондогдоржийн Эрдэнэбат

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2016 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайдаар Жаргалтулгын Эрдэнэбатыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

### **Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай**

Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг 2016 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс товлон зарласугай.

2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2016 оны 10 дугаар сарын 19-ний өдөр байхаар тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар  
хот

### **Авлигатай тэмцэх газрын даргыг томилох тухай**

Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Авлигатай тэмцэх газрын даргаар Хүрэлсүхийн Энхжаргалыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 215

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

“Болзол батлах тухай” Улсын Их Хурлын 2009 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 33 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 9-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон, Сангийн сайд Б.Болор, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 1998 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 211 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД**

**Ц.ЦОЛМОН**

Засгийн газрын 2016 оны 215 дугаар  
тогтоолын хавсралт

### **ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБЫГ МӨНГӨН ТӨЛБӨРИЙН ХЭЛБЭРЭЭР ОРЛУУЛАН ХААХ ИРГЭНИЙ ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, МӨНГӨН ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХ, ХУРААН АВАХ, ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ АШИГЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг зарцуулах үйл ажиллагаанд энэ журмыг дагаж мөрдөнө.

1.2. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж болно.

1.3. Энэ журмыг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол” болон “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг тогтоох сүлжээ”-г тус тус баримтална.

Хоёр. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн  
төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо  
бүртгэл хөтөлнө

2.1. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангаж, мөнгөн төлбөр төлөх иргэн (цаашид “төлбөр төлөгч иргэн” гэх)-ий тоо бүртгэлийг аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (цаашид “Цэргийн штаб” гэх) эрхлэн хөтөлнө.

2.2. Иргэн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах хүсэлтээ тухайн жилийн цэргийн тоо бүртгэл болон ээлжит цэрэг татлагын үеэр аймаг, нийслэл (дүүрэг)-ийн цэрэг татлагын товчоонд гаргана.

2.3. Цэргийн штаб цэрэг татлагын товчооны санал болон Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоол, тухайн жилийн мөнгөн төлбөрийн хэмжээ тогтоосон Засгийн газрын шийдвэрийг тус тус үндэслэн төлбөрийн хэмжээг тодорхойлж, нэрсийн жагсаалт гаргах бөгөөд уг жагсаалтыг аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргаар батлуулан Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (цаашид “Санхүү, төрийн сангийн хэлтэс” гэх)-т хүргүүлнэ.

2.4. Цэргийн штаб мөнгөн төлбөр төлөх тухай мэдэгдэх хуудсыг төлбөр төлөгч иргэнд хүргүүлнэ.

2.5. Цэргийн штаб төлбөр төлөгч иргэн мөнгөн төлбөр төлсөн буюу түүнийг төлбөрөөс чөлөөлсөн тухай тэмдэглэгээг цэргийн үүрэгтний үнэмлэхэд хийж, Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран баталгаажуулна.

Гурав. Мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах

3.1. Төлбөр төлөгч иргэн мөнгөн төлбөрийг цэргийн албаны дараагийн ээлжит татлагын өмнө Санхүү, төрийн сангийн хэлтсийн дансанд тушаана.



3.2. Санхүү, төрийн сангийн хэлтэс Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын 50 хувийг Сангийн яамны Төрийн сангийн тусгай дансанд төвлөрүүлнэ.

3.3. Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол”-ын “8”-д заасан тохиолдолд иргэнийг цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаас чөлөөлнө.

3.4. Энэ журмын 3.3-т заасан болзлын “8”-ын 1-д заасан үндэслэлээр цэргийн жинхэнэ алба хаахаас чөлөөлөгдөж байгаад хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрэхээс өмнө уг үндэслэл нь үгүй болсон иргэн цэргийн жинхэнэ алба хаагаагүй бол хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрмэгц тухайн жилийн мөнгөн төлбөрийг Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан хувь хэмжээгээр төлнө.

#### Дөрөв. Мөнгөн төлбөрийг зарцуулах

4.1. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын 50 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын шийдвэрийн дагуу Цэргийн штаб дараах зориулалтаар зарцуулна:

4.1.1. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс болон батлан хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

4.1.2. орон нутгийн хамгаалалтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

4.1.3. аймаг, нийслэл (дүүрэг)-ийн цэрэг-техникийн бүртгэлийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх;

4.1.4. Цэргийн штабын бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

4.1.5. дайчилгаатай сургуульд оролцох болон дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах, сургалтын материаллаг баазыг бүрдүүлэх;



4.1.6. аймаг, нийслэлийн батлан хамгаалах газар, сум, дүүргийн батлан хамгаалах товчооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

4.1.7. аймаг, нийслэл (сум, дүүрэг)-ийн улсын дайчилгааны асуудал хариуцсан ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

4.1.8. Цэргийн штаб үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;

4.1.9. батлан хамгаалах үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд идэвх, санаачилгатай ажилласан иргэн, албан тушаалтныг урамшуулах.

#### Тав. Хяналт, хариуцлага

5.1. Цэргийн штаб тухайн жилийн орон нутгийн төсөвт төвлөрсөн цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлого, түүний зарцуулалтын талаар Шилэн дансны тухай хуулийн дагуу иргэдэд нээлттэй мэдээлж байна.

5.2. Мөнгөн төлбөрийн орлогыг санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрөлгүй өөр бусад дансанд шилжүүлэх, түр байршуулахыг хориглоно.

5.3. Мөнгөн төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тухайн орон нутгийн хөндлөнгийн аудитын байгууллага, батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлын хэрэгжилтэд уг байгууллагын стратегийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж тус тус хяналт тавьж ажиллана.

5.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлын хэрэгжилтийн тайланг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан маягтын дагуу хагас жил болон жилийн эцсийн байдлаар гаргаж, батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.5. Энэ журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, иргэнд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 217

Улаанбаатар  
хот

### Журамд нэмэлт оруулах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Журам батлах тухай” Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлд дор дурдсан заалт нэмсүгэй:

“4.1.56. Хүний нөөцийн ажилтны өдөр-жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдөр”

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

**ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Г.БАЯРСАЙХАН**

#### Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medecelel@parliament.mn](mailto:turiin_medecelel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 14003